

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 01/287 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын захирал (Б.Алтансүх)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 681 дүгээр тогтоолын хавсралтын 1 дүгээр мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 2-4 дүгээр мөрөнд заасан Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны ... дүгээр сарын-ний өдрийн
...дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,830.0	
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/Гж	46,545.5
		тогтмол	Төг/м ³	1,496.8

--oOo--

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны ... дүгээр сарын-ний өдрийн
....дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН
ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,600.0	
	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/Гж	42,762.0
		тогтмол	Төг/м ³	1,375.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,400.0	
		Төг/Гж	9,075.0	
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	3,533.0	
		Өрх/төг	16,363.0	

--oOo--